



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/80

Мандалговь

Ахмадад ээлтэй байгууллага  
шалгаруулах тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.11 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/493 дугаар захирамжаар батлагдсан журмын 5.4 дүгээр заалт, 2017 оны А/492 дугаар захирамжаар батлагдсан "Ахмад настны талаар 2018-2021 онд баримтлах бодлого"-ын 5.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 4 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Ахмадад ээлтэй байгууллага"-ын шалгуур үзүүлэлтийг хангаж 4,79-4,87 оноо авсан Эрдэнэдалай сумын хүүхдийн цэцэрлэг, Луус сумын ЕБСургууль, Сайнцагаан сумын улсын тэргүүний 3-р цэцэрлэгийг 2018 оны "Ахмадад ээлтэй байгууллага"-аар шалгаруулж тус бүрийг өргөмжлөл, 200000 (Хоёр зуун мянга) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шагналд шаардагдах 600000 (Зургаан зуун мянга) төгрөг, өргөмжлөлийн 120000 (Нэг зуун хорин мянга) төгрөг, нийт 720000 (Долоон зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190212

Аймгийн Засаг дарын 2019 оны 02 дугаар  
сарын...ны өдрийн... дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



д/д	Сумдын нэр	Байгууллагын нэр	Олгох		
			Шагнал	Өргөмжлөл	Дүн
1	Эрдэнэдалай	Хүүхдийн цэцэрлэг	200000	40000	240000
2	Сайнцагаан	Улсын тэргүүний 3-р цэцэрлэг	200000	40000	240000
3	Луус	Ерөнхий боловсролын дунд сургууль	200000	40000	240000
	Дүн				720000